

## ЖАЛХАНЗ ХУТАГТ ДАМДИНБАЗАРЫН НЭГЭН СУРГААЛИЙН ТУХАЙ

Л.Нямсүрэн

Монгол Улсын Их Сургууль, Ховд дахь салбар сургууль.

*Өгүүллийн товч утга: ХХ зууны эхэн үеийн Монгол орны нийгэм улс төрийн амьдралд томоохон хувь нэмэр оруулсан төр, шашны зүтгэлтэн хутагт хувилгаад үлэмж билээ. Тэдний нэг нь Монголын төр шашны нэрт зүтгэлтэн Жалханз хутагт С.Дамдинбазар (1874-1923) бөлгөө. Жалханз хутагтын шашин төрийн үйлсийг эрхэлж ахуйдаа айлтгаж сургасан, бичиж туурвисан зүйлсүүд багагүй бий. Тэрхүү олон айлтгал сургаал, туурвилуудыг түүний шашин номын болоод нийгэм, улс төрийн үйл ажиллагаанаас ангид авч үзэх боломжгүй юм.*

*Түлхүүр үг: Төр, шашин, хутагт хувилгаад, их, бага таван ухаан.*

С.Дамдинбазар Жалханз хутагтын VIII дүрээр тодрон Жалханзын хүрээнд залагдсаны дараа 1879-1892 он хүртэлх хугацаанд Их хүрээний агримба Жигжид, Бишрэлт вангийн хошууны эрдэмтэй лам Агваанжамбажалцан, агримба Пунцаглхүндэв, агримба Мижирдорж, Богдын ёнзон Гонсор Бүрлгүү Лувсанбалданчоймбол зэрэг их номч, эрдэмтэн лам нарт шавь орж, буддын шашны ёс зан үйл хийгээд их бага таван ухааныг заалган шашны эрдэм номонд эрчимтэй суралцжээ.

Түүнийг багш нар нь ... бага балчир цагаас нь хатуу чанга барьж "Хутагтын зүүвэр нэрэн дор хурга, торго хоёрт хөлбөрч, хуурмаг хөдхийн оюунт нэгэн болгохгүйн" тухайд үгийг хатуу, суртахууны чангаар "торлогдож" хүмүүжүүлсний ачаар ... төвдийн сав, шар үсэг, монгол бичиг тэргүүтнийг унших бичихэд суралцаж, бие, хэл сэтгэлийн гурван хаалгыг сонсох, санах, бясалгахын гурван эрдэм, номлох, тэмцэх, зохиохын гурван үйлийг төгс нээжээ.<sup>1</sup>

Жалханз хутагт Дамдинбазар нь чойрын хийгээд нотлох ухааны номыг нэлээд гүнзгий судалсан хэдий ч албан ёсоор гавжийн дамжаа бариагүй, мяндаг тушаал аваагүй байна. Энэ тухайгаа тэрээр "сургууль хийгээгүй атлаа мяндаг нэрийн хэрэг юун. Таван боть их онолыг гүйцэд мэдэхгүй байж тушаал хэргэмийн хэрэг юун" хэлж байжээ. Харин хутагт бол Лхас болоод Энэтхэгийн шашны болон гүн ухааны дээд сургуульд олон жилээр сууж суралцаагүй бололтой. Бурханы шашны хийгээд бусад салбарын шинжлэх ухааны мэдлэг боловсролыг багш нарын удирдлаган дор ихэвчлэн бие даан сурч эзэмшсэн байна<sup>2</sup>.

Буддын ном сургуулыг шамдан үзэж гэгээрэн, тухайн үеийнхээ нийгэм-улс төрийн амьдралтай танилцан, оюун ухааны цар хүрээ нь тэлэн хөгжиж байсан ид насандаа XV жарны төмөр барс жил буюу аргын 1890 онд VIII Богд Жибзундамбатай уулзаж учирсан нь Дамдинбазарын цаашдын амьдрал үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлсэн юм.

XV жарны усан луу жил буюу аргын 1892 онд Жалханз хутагтыг Их хүрээнээ чойрын болоод сүмбүмийн ном үзэж ахуйд Жибзундамба хутагт түүнийг дуудаж чухалчлан уулзжээ. Энэ тухай Жалханзын намтарт "Жалханз хутагтыг намрын налгар нэгэн өдөр Богд Жибзундамба дэргэдээ дуудаж айлдан соёрхохдоо: Одоогийн хүнийг үзэхэд хайш яйш итгэмжгүй нь их байх юм. Ер нь хичээн хянах цаг болсон тул танд би шашин төрийн хүнд үйл хэргийн үүргийг хүлээлгэхийн дээр бас өөрийн шадар хамбаар ажиллуулах гэж бодож байна. Түүгээр ч барахгүй одоо бид нар ямар зүг явахын хэмжээг нарийвчлан эс мэдэх тул миний санасан бүх хэргийг та л бүтээх хэрэгтэй ... гэх зэргээр маш их учир шалтгааныг дотночилж нарийвчлан айлдсанд гэгээнтэн нэгд: багшийн зарлигийг бүтээхээс илүү анхааран авалт гэж байхгүй хоёрт: шашин амьтны тусад буян

<sup>1</sup> Л.Хүрэлбаатар. Огторгуйн цагаан гарди. УБ., 1998 т 306

<sup>2</sup> Б.Лааган. Жалханз хутагт Дамдинбазар. УБ., 1994 т 11

үйлдэхээс илүү зүйлгүй юм гэж таалаад, тэр тушаалыг чамлах, гоёмсгоор чөлөө гуйх зэргээр хариу айлтгасангүй зарлигийг шууд хүндлэн хүлээлээ”<sup>3</sup> гэжээ.

Ийнхүү Жалханз хутагтыг Богд гэгээн тухайн цагийн эрдэмтэн, мэргэд олны дотроос сонгон “Хамба номун хан” цол хайрлан, улмаар өөрийн шадар хамбын албан тушаалд томилж, гадаад, дотоод шашин төрийн бүх хэргийг даалгасан явдал бол түүний ... түүх уламжлалаа мэдэж хүндлэх, шашин номын ёсоо чанд баримтлан түмэн олны сайн сайхны төлөө өөрийн биеийг үл бодон зүтгэх, дээдэс доордос гэж ялгахгүй нигүүлсэнгүй хандах, шашин төрийн хэрэгт шударга ёсыг баримтлах зэрэг эрхэм зан чанар<sup>4</sup> нь төр шашны зүтгэлтнүүдийн анхаарлыг зүй ёсоор татсаны илрэл бололтой.

Үнэхээр ч Жалханз хутагт Дамдинбазар: “Эрдэм номоор бага боловч номлон явагч хүнийг энэрэн магтдаг. Эрдмийн их боловч омгоор магтагч, өөр бусад хоёрын үндсийг сүйтгэгч нар ном эрдэм сураагүй мөртлөө номч мэт засдаг гэлэн, таримч, ямар нэгэн хуурамч засдагуудыг угаас буруушаадаг, юуг үйлдэвч шударгыг эрхэм болгодог ... хүнтэй нөхөрлөхдөө ил баясаж, далд муулах сайн муу зан ааш огт гаргадаггүй... “Унаж явж морио, ханилж сууж нөхрөө” гэдэг үгийг эрхэмлэдэг, бусдын сайн мууг хэлэх явдалд баясаж хууртдаггүй... бусдыг хатуу үг, эрх хүчээр эрхэндээ оруулж эд хогшил, олз омгийн хойноос хөөцөлдөх гэдэг муу гэмийг үзэж, түүнийг хатуу донгодон буруушааж зэмлэдэг”<sup>5</sup> хүн байв.

Тухайн үед ... хутагтын (Жибзундамба Л.Н) шадар ойрхны хүмүүс сургууль соёлыг анхаарч хийдэггүй, хутагтын үйл хэргээр далимдуулан ном бус гэмт хэрэг үйлдэгчид олон. Эдгээр нь хувь хувиа бодож эд баялгийн шуналаар нэрвэгдэн баяр цэнгэлдээ ташууран буруу явдалд орсон<sup>6</sup> байжээ.

И.Майский "... Богд гэгээний дэргэд ч улс төрийн маш чухал үүрэг гүйцэтгэгч ордны зэс хошуутнууд (хувийн ашиг хичээсэн хутган үймүүлэгч бүлэг) байдаг аж. Эл бүлгийн амин сүнс нь Богд гэгээний хатан, гол оролцогчид нь төрийн үйл хэрэгт мэдэгдэм нөлөө үзүүлэгч дээд мяндагтан лам нар байх ажээ. Богд гэгээн шадар дотно эдгээр лам нарынхаа аль нэгний танилцуулгыг үндэслэн сайд нарын танхимдаа мэдэгдэлгүй чухал зарлиг, захирамж гаргах тохиолдол ч гардаг<sup>7</sup> хэмээн өгүүлсэн байдаг.

Чухамхүү энэ үед VIII Богд Жибзундамба хутагтын “Гүжир хамба”-ын сонголт маш оновчтой зөв байсан агаад Жалханз хутагт Дамдинбазар шашин төрийн үйл хэргийг зөөлөн үед нь зөөлөн, хатуу уян байж эрхлэн зөв гольдиролд нь оруулахын хичээн ажиллажээ.

Энэ тухай Элбэгдорж Ренчино бичихдээ "...Жалханз хутагт ... ордны коменданттай төс бүхий “Гүжир хамба” цолтой, Богдын ойрын шадар туслагч байв... Жалханз хутагт засаглалыг хэвийн хэмжээнд явуулахын тулд ордны доторхи ноёд түшмэд, зарц барлагуудын ужид самуун шалиг завхай явдалтай эрс шийдвэртэй тэмцэж шийтгэж байсан нь түүнийг алдаршуулсан юм<sup>8</sup>” гэжээ.

Төр засаглалын үйл ажиллагааг хямралаас гаргах Жалханз хутагтын бодлогыг эсэргүүцсэн хүмүүс цөөнгүй байсан ба Богд Жибзундамба хутагт, Жалханз хутагт хоёрт "...Андуу нарын ноён ... "Жалханз, жалханз л гэнэ. Чи баруун аймгийн нэг шаврон, тэндээ суухгүй шавь нараа орхиод яах гэж энд сууж байна. Манай буман шавиас бараа болох хүн олдохгүй гэж чи ингэж байна уу<sup>9</sup>” гэж агсан тавьж байсан гэдэг. Тэр ч атугай... Хүрээ 5 яамдаар гэгээнийг морилж

<sup>3</sup> А.Лхасүрэн. Цагаан лянхын баглаа сайн чуулганы үүдийг нээгч. УБ., т 11-12

<sup>4</sup> Г.Очирбат. Хоёр их хутагтын нийтлэг шинж. Хоёр их хутагт. УБ., 1994 т 62

<sup>5</sup> А.Лхасүрэн. Мөн тэнд. т 14

<sup>6</sup> А.Лхасүрэн. Мөн тэнд. т 12

<sup>7</sup> И.Майский. Орчин үеийн Монгол. (Автономит монгол XX зууны гараан дээр) УБ., 2001 т316-317

<sup>8</sup> Дзасагту-Хановский аймак Рукопись из фонда Э.Д.Ринчино. 1922. Элбек-Доржи Ринчино о Монголии. Улан-Удэ., 1998 стр 142-143

<sup>9</sup> Ц.Дамдинсүрэн. Ёвгөн Жамбалын яриа. УБ., 1959 т 34-35

ирэх болоход цэвэрлэгээ хийх, ажил үйлсээ танилцуулахаар бэлтгэж, их хөл болдог... Зарим түшмэдүүд нь Богдын ширүүн хар ирэх нь гэж эмээдэг байсан<sup>10</sup> ажээ.

VIII Богд Жибзундамба хутагт төр засагт үнэнчээр хүчин зүтгэж буйг өндөр үнэлэн, ... Жалханз хутагтад хөх бүс, нандин Пүрэв,... өндөр богдын өөрийн урлан хийсэн Гомбо бурхан, Арлозвагийн гавал эрхи... зэрэг ховор шүтээнийг хайрлахын хамт Жалханзад зориулан ... голын шар хашааны зүүн талд орд бариулж "Шашин хэзээ буй цагт энэ орд байсугай"<sup>11</sup> хэмээн буулгаж байв.

Ийнхүү Жалханз хутагт... шашин, төрийн үйл хэргийн нарийн амьдралд орсон бөгөөд ингэснээр түүний төрийн түшмэлийн ухаан бодлого төгөлдөржиж... өөрийн үзэл санаагаа хэрэгжүүлэх боломжтой болсон<sup>12</sup> төдийгүй... нийгэм, улс төр, шашны үйл хэргийг зөвхөн шавь нутгийн хэмжээнд биш улс орны цар хүрээгээр сэтгэн бодох билэг оюун нь тэлсэн байна<sup>13</sup>.

Тэрээр "Гүжир хамба" хэмээх шашин төрийн хэргийг хавсран шийтгэх Богд эзний шадар дэргэдийн зөвлөхийн албыг хашиж, Хүрээнд сууж ахуйдаа өөрийн харъяат шавь олондоо тэдний хүсэлтийн дагуу цагийн эндүүрэлд үл автахыг захисан сургаал хайрлажээ. Энэхүү сургаал нь цагийн амьсгал ээдрээ хивцаантай үед шавь олноо хэрхэн ёс журмыг сахиж, эвийг эрхэмлэн, шашин төрөө дээдлэн явахын чухлыг ..."ухуулан хоригсох зүйлүүдийг та нар минь үнэмширлэн мэдэж танихгүй болвоос би энд суух хэрэггүй. Хэрэв миний хэлснийг ёсчлон сүслэн дагаваас сайн буяны хөрөнгө босгож шавь нар олон амьтан бүхнийг юугаан эцэг мэт тэтгэж, эх мэт асарч сахиус мэт сахиж шашин амьтныг тусалж шавднаа бататгаж суу"<sup>14</sup> хэмээн арга билгийн ёсонд тулгуурлан зааж сургасан Жалханз хутагт Дамдинбазарын анхны нь гэгээн айлдвар ажээ.

Жалханз хутагт Дамдинбазарын эл сургаал өдгөө Улсын нийтийн номын сангийн хуучин номын фондын гар бичмэлийн тасагт хадгалагдаж байна. "Жалханз хутагтын сургаал" гэсэн гарчигтай бөгөөд хятад моуту цаасан дээр хар бэхтэй бийрээр, худам бичгээр нямбайлан бичсэн гурван хуудас бүхий сургаал ажээ.

Бадаргуулт төрийн арван долдугаар он, арван сарын есөн буюу 1892 оны өвөл Жалханз гэгээн 19 настай байхдаа сургаалаа бичжээ. Тус сургаалыг жинхэнэ эх нь үү? Эсвэл хуулбар уу? гэдгийг тогтооход бэрхтэй. Сургаалын эхэнд "Шанзудва хар шарын мэдээчин нар" гэснээс үзэхэд харъяат шавь ард олондоо хуулбарлан тархаахын чухлыг гэгээн чухалчилсан бололтой.

Юун боловч миний санахад "... гэгээн танаа шавдан бат заларч, шашин амьтны тусыг үйлдэх ба ... ном айлдаж бүхүйд ... шавь нар нийтээр олж хүртэхийг хүсэцгээж, мандал өргөж айлтгаваас гэгээн таны лүндэн<sup>15</sup> " гэснээс үзэхэд уг сургаал жинхэнэ эх бус хуулбар байж болох магадтай. Гэвч цаашид түүнийг нарийвчлан эх бичиг судлалын үүднээс судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Тус сургаалын гол агуулга нь хүнлэг энэрэнгүй ёс, шударга үнэнийг эрхэмлэхийг чухалчлахын зэрэгцээ төр засгийнхаа бодлого үйл ажиллагааг дэмжих, хүндэтгэхэд чиглэсэн байх төдийгүй бурханы шашны онол номлол болоод үзэл санаанд сүсэгтэн олноо үнэнч байхыг уриалсан шинжтэй юм.

<sup>10</sup> С.Дармаа. Миний авга ах Дамдинбазар. Хоёр их хутагт. УБ., 1994 т 49

<sup>11</sup> А.Лхасүрэн. Цагаан лянхын баглаа сайн чуулганы үүдийг нээгч. УБ., т 12

<sup>12</sup> Г.Очирбат. Жалханз хутагт Дамдинбазар 1911 оны Монголын үндэсний хувьсгалын удирдагчдын нэг мөн. "Манай Монгол" сэтгүүл. УБ., 1999.т 50.


<sup>13</sup> Б.Лааган. Жалханз хутагт Дамдинбазар-Монголын улс төрийн зүтгэлтэн. Хоёр их хутагт. УБ., 1994. т 23.

<sup>14</sup> Жалханз хутагтын сургаал. УННС гар бичмэл

<sup>15</sup> Мөн тэнд т 1.


Жалханз хутагтын сургаалыг худам монголоос шинэ үсэгт хөрвүүлэн буулгаснаа хавсаргаж, уншигч таны гэгээн мэлмий, билэг оюунд хүргэхийн ялдраа эндүүрч ташаарсан зүйл буй аваас гүнээ хүлцэл өчмүй.

Жалханз хутагтын сургаал



Бадаргуулт төрийн арван долдугаар он, арван сарын арван есөн. Шанзудва, хар шарын мэдээчин нар

Гэгээн танаа шавдан бат заларч, шашин амьтны тусыг үйлдэх ба чинадад хаалгасан бас энэ он хоёр сард ном айлдаж бүхүйд хаалгасан зүйлүүдийг шавь нар нийтээр олж хүртэхийг хүсцгээж, мандал өргөж айлтгаваас гэгээн таны лүндэн нь хутагтын урьд Энэтхэгийн оронд нас бага шид олоогүй явах цагт замбага цэцэг түүж явахад нэгэн их Донба<sup>16</sup> лугаа учирч, түүний айлдсан нь: Чи энд идид суумай. Чи олвоос хязгаар газрын хэрцгий



амьтныг номхтгогч шажин амьтны туслан явах учиртай буй хэмээн шид олдож илгээсний тулд энэ оронд ирсээр олон удаа үед хувилан дүрийг үзүүлж, шажин амьтны тусыг үйлдэж шарын шашныг дэлгэрүүлэн тэтгэж буй бөлгөө.

Энэ он хоёр сард мөнхүү амьтны тусыг санаж Солдэвийг<sup>17</sup> уншиж, ловон чинбу Бадамжунай<sup>18</sup> залбирч санатал олон амьтан нь найдангуй сэтгэл ихдэж, алба тушаалын хүн албагүй дорд хүнээ басамжлах ба албагүй хүн алба тушаалын хүнийг илүүд үзэж атаархах ба баян хүн үгүй ядуугаа доромжлох, ядуу хүн баян хүнээ илүү үзэх тэргүүтнээр бие биений


<sup>16</sup> Их багш

<sup>17</sup> Соёрхол, сургаал

<sup>18</sup> Сургаалийн их багштан Бадамжунай. Ловон Бадамжунай нь Үржин орны баруун хойд зовхист Данагаша хэмээх нуурын лянхуа цэцгээс хувилан төрсөн домогтой ажээ. Лянгуагаас мэндэлсэн тул Бадамжунай буюу Лянхуагаас төрсөн орон хэмээх нэртэй ажгуу. Энэ ловон нь нууц тарнийн Нинмава ёсыг үндэслэгч юм.




Номын хутагт би болвоос Богд эзэн өршөөлд Халхын



Засагт хан аймгийн Жалханз хутагтын хувилгаан мөн хэмээн заагдсанаар аймаг олонд тахигдсан, шашныг тогтоон үйлдсээр нь бүгд, би шашин төрд харштай гагцыг буруу явдал үйлдсэн аваас Богдын хаан багш Жибзундамба хутагт нарын газраас хориглож, буруушаах учир буй боловч надад басхүү айлтгал буй билээ.

Бусад эгэл төрөлхтөн хэн бээр ч хэлэх учир үгүй амуй. Өөрийн биеэр дуусгахаас бусад хүн амьтныг дагуулах зүйл огт үгүй. Харин ч бусдын бурууг арилгах эзэн бус миний хийсэн ямарваа буруу явдалд та бүхэн миний холбогдох зүйлгүй биш үү.



Би гурван үед хоёр уншлага сайн гүйцсэнгүй. Гэвч хоёр уншлагаас бусад зүйлийн номуудыг гүйцэн чадах болов уу хэмээн санамой. Одоо миний шавь болсон та бүхэн миний эв тангаргийн чинадад хичээе.

Ялангуяа хуврага төрлүүд минь тангараг санваараа сайтар сахиж, сэтгэлийн угийг ном лугаа нийлүүлэн бусдын гэмийг үл өгүүлэн, өөрийн гэмийг боомдлон гэмшиж хутагт миний ямар зүйлээр явах, цаасан буу талбих зэрэг замаар гүйлэн үйлдэхийг бурууд үл үзэн хориглох зүйл байлтай боловч надад багш болсон хүн хэлвээс зохих болтугай ч мөн тухайд учрыг би айлтгаж хэлэх зүйл буй болой.

Та бүхэн минь хутагт

